



УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/17/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261683 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdaiaid@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: М.Ганбаатар
Утас: 261628 Цахим хаяг: ganbaatar@audit.gov.mn
Аудитор: Я.Марал-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeney@audit.gov.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15.00 Улаанбаатар хот, Нияглан дүүрэг
 Саяа хийгээ-3, Нийслэл төвний 10 баар
 Утас 24-64-37, Факс-51 36 42-50
 E-mail info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН
 АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 Б.АМАРСАНАА ТАНАА

2024.02.23 № 07/288

ТӨСВИЙ

НИЙТЭ

Т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын зээлийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 176,659,488.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1, 76 дугаар зүйлийн 76.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын зээлийн сан нь төвлөрсөн төсөвт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн 1993 онд Шинжлэх ухаан, боловсролын яамны дэргэд "Сургалтын төрийн сан" нэртэйгээр анх байгуулагдаж, тайлант онд байгууллагын 30 жилийн түүхт ой тохиосон байна. Үүсэн байгуулагдсан цагаасаа сурах хүсэл эрмэлзэлтэй, гадаад дотоодын их дээд сургуульд элсэх шалгуур хангасан боловч сургалтын төлбөрийн дэмжлэг шаардлагатай суралцагчдад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Өндөр хөгжилтэй оронд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцсан нийт 462 суралцагчийн 12,635,722.97 ам.долларын зээлийн, 159 суралцагчийн 2,941,237.9

ам.долларын хүүгийн авлагын, Дэлхийн шилдэг их сургуульд суралцсан 164 харилцагчийн 19,591,404.91 ам.долларын зээлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй байна. Үүнээс гэрээний үүргээ биелүүлээгүй нийт 3,438,011.98 ам.долларын санхүүжилт авсан 147 эзэлдэгчтэй холбоо тогтоогоогүй, зээлийн эргэн төлөлтийн график байгуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын хамрах хугацаанд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсгээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж, сангаас 1997-2023 оны санхүүгийн баримт материалыг эд мөрийн баримтаар хураан авч, шинжилгээнд хүргүүлсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуусал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана" гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны 2023 оны 8и-3/12308 дугаар бүхий албан бичгээр холбогдох баримт материалыг Үндэсний аудитын газарт хүргүүлэх боломжгүйг мэдэгдсэн тул аудитын баг Боловсролын зээлийн сангаас 2023 онд зээлээс чөлөөлсөн суралцагчдын анхан шатны баримтад аудит хийгдээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. P. W.

Ц.НАРАНЧИМЭГ

валютаар тусгах, эргэн төлөлт хийхэд аль ханшийг мөрдөх болон гадаад болон дотоод тэтгэлэг, буцалтгүй тусламжийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, дотоод хяналтын талаар нарийвчлан тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2008 оны 368 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,283.6 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,060.2	-	(1,060.2)
Болоно хугацаат хөрөнгө оруулалт	305,900.6	144,465.8	(161,434.8)
Авлага	274,061,473.5	257,856,401.3	(16,205,072.2)
Урьдчилгаа	33,926,894.1	43,012,448.5	9,085,554.4
Бараа материал	12,000.0	-	(12,000.0)
Үндсэн хөрөнгө	181,323.7	191,750.8	10,427.1
Нийт хөрөнгө	308,488,652.1	301,205,066.4	(7,283,585.7)
Өр төлбөр	4,353.0	-	(4,353.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	308,484,299.1	301,205,066.4	(7,279,232.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгөтөмчийн дүн	308,488,652.1	301,205,066.4	(7,283,585.7)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 16,205,072.2 мянган төгрөгөөр буурсан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/83 дугаар тушаалаар 10,227,182.2 мянган төгрөгийн гадаад зээлийн авлагыг чөлөөлсөн болон тайлант онд 1,526,245.3 мянган төгрөгийн гадаад зээлийн, 2,389,157.5 мянган төгрөгийн оюутны зээлийн эргэн төлөлт хийгдэж авлага барагдуулсан;
- Урьдчилгаа данс 9,085,554.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Дэлхийн шилдэг их сургуулийн сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутнуудад олгосон 8,950,958.5 мянган төгрөг, Өндөр хөгжилтэй оронд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа оюутнуудад 316,454.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 301,205,066.4 мянган төгрөг болж 7,279,232.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 129,653,665.3 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал засварын зардлыг 67,667,790.6 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 61,985,874.7 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн саналыг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "Дээд боловсрол" хөтөлбөрийн 14 зрлг хэмжээг санхүүжүүлэхээр 91,985,874.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт төвлөрүүлэх эрхтэй төлөгдөн цэвэр зээлийг 30,000,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 68,521,107.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 60,182,586.0 мянган төгрөг зарцуулж, төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 57,365.2 мянган төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлээс 8,281,155.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,109,074.4	1,101,559.9	7,514.5	99.3
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	36,371.5	35,567.4	804.1	97.8
3	81404 Дамжуулан зээлдүүлсэн зээл	(30,000,000.0)	(8,281,155.9)	(21,718,844.1)	27.6
4	81812 ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоод	1,110,040.8	1,099,140.7	10,900.1	99.0
5	81813 Зарим суралцагч (нэн адуу, мал	14,453,197.1	14,175,645.6	277,551.5	98.1
6	81814 Орон нутгаас суралцаж буй оюут	881,032.6	881,032.5	0.1	100.0
7	81826 Багш мэргэжлээр суралцаж буй о	1,536,771.1	1,536,771.0	0.1	100.0
8	81828 Орон нутагт хийх багшлах дадлага	351,365.8	350,682.7	683.1	99.8
9	81846 Боловсролын зээлийн сан	17,332,801.6	5,792,547.3	11,540,154.3	33.4
10	81849 Сувилагч мэргэжлээр суралцагсдын тэтгэлэг	5,270,592.1	5,268,542.1	1,950.0	100.0
11	81851 Гадаадад суралцагсдын зээл	14,487,460.1	9,288,792.2	5,218,667.9	64.0
12	81852 ЗГ-н гэрээгээр гадаадад суралцагсдын тэтгэлэг	3,930,989.3	3,413,606.4	517,382.9	86.8
13	81853 Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	22,563,268.7	20,038,814.4	2,524,454.3	88.8
14	81854 Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	8,922,909.6	5,500,839.7	3,422,069.9	61.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Оюутны хөгжлийн зээлийн 4,260.2 мянган төгрөгийн хүүгийн орлого орсныг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамваралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор гэрээний үүргийн хэрэгжилт, журам, урьдчилгаа дансны бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, орлого бүрдүүлэлт, сургалтын зээлийн сонгон шалгаруулалт, архивын үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор М.Ганбаатар, Я.Марал-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 308,488,652.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 1,542,443.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг 2023 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй бөгөөд гүйцэтгэлээр зарцуулалт гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 16 зөрчлөөс журам, мэдээллийн сан, төлөвлөгөө, гүйцэтгэл, сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилттэй холбоотой 9 зөрчилд албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, барьцааны зүйл, орлогын эх үүсвэр, дотоод хяналттай холбоотой зөрчилд 7 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын

заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendana.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсрол зээлийн сан нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 21 нэр төрлийн 146 мэдээллийг хутагаанд нь бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам", Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д оюутны хөгжлийн зээлийн эрсдэлийн сангийн талаар нарийвчилсан зохицуулалтгүйгээс эрсдэлийн сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай, 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Оюутны хөгжлийн зээлийн эрсдэлийн сангийн талаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д нарийвчилсан зохицуулалт оруулаагүй, эрсдэлийн сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

2. Гэрээний үүргээ биелүүлээгүй, авлага үүсгэсэн төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, ажилласан жил, холбоо барих хаяг, утасны мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргуулан авах талаар гэрээ болон холбогдох журмуудад тусгасан зүйл, заалтгүй, мэдээллийн эзнээс гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох байгууллагуудаас тухайн хүний талаар мэдээллийг гаргуулан авах зөвшөөрлийг цаасан болон цахим хэлбэрээр авч баталгаажуулаагүй байна.

Энэ нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл, Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах 8.1-д "Мэдээлэл хариуцагч хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна", 8.3-т "Мэдээллийн эзэн зөвшөөрлийг мэдээлэл хариуцагчид бичгээр өгөх бөгөөд энэ зөвшөөрөл нь цаасан, эсхүл цахим хэлбэртэй байна" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага үүсгэсэн төгсөгчдийн мэдээллийг гаргуулан авах зөвшөөрлийг цаасан болон цахим хэлбэрээр авч баталгаажуулаагүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

3. Олгосон гадаад зээл болон оюутны хөнгөлөлттэй зээл, дэд зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн сан, Сангийн яамны өрийн удирдлагын мэдээллийн санд бүртгүүлээгүй, зээл олгох шийдвэр гаргалтад зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны "Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай" 87 дугаар тогтоолын 6.11-д "Олгосон зээл, дэд зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн сан, Сангийн яамны өрийн удирдлагын мэдээллийн санд тогтмол бүртгүүлэх, зээл олгох шийдвэр гаргалтад зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олгосон зээл, дэд зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн сан, Сангийн яамны өрийн удирдлагын мэдээллийн санд бүртгүүлээгүй, зээл олгох шийдвэр гаргалтад зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ", 48.5-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

5. Дэлхийн шилдэг 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах эрх авсан, сургалтын зээлийн хөтөлбөрт хамруулах иргэнийг сонгон шалгаруулалтад баримтлах ажлын удирдамжийн Тав. "Шалгаруулалтын үе шат. 2023 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд ярилцлагын шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулна", Зургаа. "Сонгон шалгаруулалтын үнэлгээний аргачлал. Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалт шалгуур үзүүлэлт ба үнэлгээ өгөх аргачлал", Долоо. "Комиссын үйл ажиллагаа: 9-д Ярилцлагыг баталсан хугацаанд танхимгаар болон цахим хэлбэрээр хийх бөгөөд ярилцлагыг видео хэлбэрээр бүтэн бичлэг хийж, архивад хадгална", 10-д "Комиссын гишүүд ярилцлагад оролцогчдоос энэхүү удирдамжид заасан үнэлгээ өгөх аргачлалын хүрээнд юу ч тооны асуулт асууж, хариулт авна" гэж тус тус заасан. олон нийтэд зар тавьсан боловч Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/256 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар журамд заасан суурь шаардлага хангасан иргэдийн суралцах чадварын ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, өмнөх ажлын хэсгийн сонгон шалгаруулалтад оролцох иргэдээс авсан ярилцлагын шалгалтыг тооцолгүй Суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалт авч үр дүнгээр нь сонгон шалгаруулалт хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 4.2-т Сонгон шалгаруулах Ажлын хэсгийн удирдамжид дараах асуудлыг тусгана.

4.2.1.шалгалтыг зохион байгуулах хэлбэр (цахимаар болон танхимаар);

4.2.2.үнэлгээний шалгуур үзүүлэлт болон үнэлэх аргачлал;

4.2.3.сонгон шалгаруулалт явуулах хугацаа;

4.2.4.гомдол маргаан шийдвэрлэх зохицуулалт;

4.2.5.сонгон шалгаруулалт явуулах Ажлын хэсгийн гишүүдийн үүрэг, хариуцлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Дэлхийн шилдэг эхний 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах эрх авсан, сургалтын зээлийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй суралцагчийг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулаагүй зөрчлийг зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

6. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/293 дугаар "Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" тушаалаар 50, А/474 дүгээр тушаалаар 6, А/475 дугаар тушаалаар 8, нийт 64 суралцагч шалгарснаас 60 суралцагч Дэлхийн шилдэг их сургуулийн 50-д багтсан их, дээд сургуулийн 50 болон түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан баримтыг ирүүлээгүй, сонгон шалгаруулалтын шаардлагад нийцээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 4.5-д "Энэ журмын "Дөрөв" дэх хэсэг нь дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Times Higher Education

World University Rankings" болон "Academic Ranking of World Universities" байгууллагын тогтоосон эрэмбээр тухайн жилийн эхний 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах, 50 ба түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээлд хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийт 64 суралцагч сонгон шалгарснаас 60 суралцагч тэтгэлэг авсан баримтыг ирүүлээгүй, сонгон шалгаруулалтын шаардлагад нийцээгүй зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

7. Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтаагүй New York University сургуулиас хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй санхүү, эдийн засагч мэргэжлээр урилга авсан 2 суралцагчийг сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 дугаар зарлигийн 1-д "Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтсан сургуульд суралцагчид хүсэлтийг нь үндэслэн суралцаж буй мэргэжлийн чиглэлийг харгалзахгүйгээр санхүүжилт олгох", Засгийн газрын 2023 оны "Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай" 116 дугаар тогтоолын хавсралт 1-д заасан мэргэжлийн чиглэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй санхүү, эдийн засагч мэргэжлээр урилга авсан 2 суралцагчийг сонгон шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

8. Сонгон шалгаруулалтад тэнцсэн 64 суралцагчийн нэг жилийн дундаж сургалтын төлбөр дунджаар 167.9 сая төгрөг, суралцах дөрвөн жилд нийт зээлийн хэмжээ дунджаар 671.8 сая төгрөг болох бөгөөд суралцагч сургуулиа гэрээний хугацаанд төгсөж эх орондоо ирж ажиллах ба 8 жилд багтаан зээлийг төлж барагдуулахаар гэрээ хийсэн байна. Энэ нь тухайн суралцагч сард ойролцоогоор 7,000.0 мянган төгрөгийг төлөхөөр байгаа нь Монгол Улсын цалингийн дунджаас хэт өндөр байгаа тул найдваргүй зээлдэгч болох эрсдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталгаажсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 6.4-т "Тадаадын их, дээд сургууль төгсөгч нь сургууль төгсөж, диплом авсан өдрөөс эхлэн 8 хүртэлх, дотоодын их, дээд сургуульд суралцагч нь төгссөнөөс хойш 6 хүртэлх жилийн дотор зээлийг төлж дууссан байхаар эргэн төлөлтийн хуваарийг гаргаж, зээлийн гэрээнд тодорхой тусгана" гэж заасан байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын төлбөрийн зээлийн гэрээнд эргэн төлөх хугацааны нөхцөл нь биелэх боломжгүй эрсдэл үүсгэж байгаа зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

9. Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь тайлант онд дээд шатны төсөв захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д "Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна", 40.3-т "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяалагдах дээд шатны төсөв захирагчтай үр дүнгийн гэрээг хуулийн хугацаанд байгуулаагүй, биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнүүлээгүй зөрчлийг зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

10. Сургалтын байгууллагад эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас зээл (хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгө)

авахад хүүгийн хөнгөлөлт үзүүлэхээр журамд тусгасан боловч журам хүчин төгөлдөр болсноос хойш хэрэгжээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.6-д "Сургалтын байгууллагад эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас зээл (хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгө) авахад хүүгийн хөнгөлөлт үзүүлнэ", 6.9-д "Энэ журмын 3.6-д заасан тусламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр гадаадын болон олон улсын байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэнтэй хамтран ажиллах гэрээгээр зохицуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын байгууллагад эрэлттэй мэргэжлээр суралцагчдын сургалтын төлбөрийн зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон хүүгийн судалгаа хийх, Боловсролын зээлийн сангийн журмуудын талаар асуумж авч, дүн шинжилгээ хийх зөвлөмж өгөв.

11. Оюутны хөнгөлөлттэй зээлийн барьцаанд авсан 13304 дипломыг ердийн модон шүүгээнд хадгалж байгаа нь бусад этгээдийн хууль бус халдлага, гэнэтийн аюулд устаж алга болох эрсдэлтэй байна. Мөн E-Mongolia цахим системээс боловсролын лавлагаа тодорхойлолт авдаг болсон өнөө цагт зээлдэгчийн диплом нь барьцааны үүртээ гүйцэтгэх боломжгүй болсон байна.

Энэ нь Хадлах эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 30.1-д "Барьцааны зүйлийг эзэмшиж байгаа этгээд барьцааны зүйлийн бүрэн бүтэн, эрхийн доголдолгүй байдлыг хангах, түүний дотор бусад этгээдийн хууль бус халдлага, гэнэтийн аюулаас хамгаалахын тулд хууль болон гэрээгээр тогтоосон арга хэмжээг авах, хэрэв энэ талаар хууль болон гэрээнд заагаагүй бол шаардлагатай ердийн арга хэмжээг авах үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Оюутны хөнгөлөлттэй зээлийн барьцаанд авсан 13304 дипломын бүрэн бүтэн, эрхийн доголдолгүй байдлыг хангах, бусад этгээдийн хууль бус халдлага, гэнэтийн аюулаас хамгаалахын тулд хууль болон гэрээгээр тогтоосон арга хэмжээг авах зөвлөмж өгөв.

12. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогийг /гэрээнд төлбөрийг ямар валютаар тусгах, эргэн төлөлт хийхэд аль ханшийг мөрдөх болон гадаад болон дотоод тэтгэлэг, буцалтгүй тусламжийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх г.м/ нарийн тусгаагүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зарим хууль, тогтоомжид нийцээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", УСНББОУС 3-т "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, тогилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн байгууллагын онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

13. Хуулиар олгосон орлогын эх үүсвэр бүрдүүлэх, нэмэлт орлого олох талаар ажил зохион байгуулаагүй нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Тусгай сан нь дараах нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ:

6.1.1.улсын төсвийн хөрөнгө;

6.1.2.хандив, тусламж;

6.1.3.тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого;

6.1.4.зээлийн хүүгийн орлого" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар олгосон орлогын эх үүсвэр бүрдүүлэх, нэмэлт орлого олох талаар судалгаа хийх, холбогдох ажлыг зохион байгуулах зөвлөмж өгөв.

14. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Комисс томилгох тухай" А/75 дугаар тушаалаар Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн суралцах иргэдийн сонгон шалгаруулалтын зохион байгуулах комиссыг байгуулахдаа Төрийн бус байгууллагын төлөөлөл оруулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг байгуулахдаа Төрийн бус байгууллагын төлөөлөл оруулж байх зөвлөмж өгөв.

15. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2014 оны А/169/93 дугаар тушаалаар батлагдсан Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг "Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай" хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна гэж тусгасан боловч уг журмыг боловсруулж, батлуулаагүй байна.

Энэ нь Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно" гэж заасантай, Боловсролын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэж/ боловсролыг хөгжүүлэх, дэмжих талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 24.1.1.энэ хуулийн 11.3, 11.4, 11.5-д заасан тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх журмыг баталж, хэмжээг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох" журмыг боловсруулж, холбогдох дээд удирдлагад хүргүүлж, шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

16. Архивын өрөө нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй, цахим архив үүсгээгүй, байнга хадгалагдах баримтуудыг улсын төв архивд шилжүүлээгүй, баримт бичиг устаж алга болох эрсдэлтэй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална", 23.2.4-т "архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах", 23.2.6-д "архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас иж бүрэн хүлээн авах, архивын баримтыг эмхлэн цэгцлэх, ангилан төрөлжүүлэх, баримтыг холбогдох журам, стандартын дагуу үдэж, хаялжуулах, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн санг бүрдүүлэх, архивын өрөөг стандартад нийцүүлэх, байнга хадгалах баримтыг хуульд заасан хугацаанд улсын төв архивд шилжүүлэх талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зарим зүйлс холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материалын дансад горим, сорил хэрэгжүүлэн, дүнг жилийн эцсийн аудитын тайланд тусгасан.

Аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 191,184,228.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,060.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 191,183,168.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснөөс төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 75.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Бялалт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,060.1	1	1,060.1	100.0
Албан шаардлага	5	191,183,168.0	3	124,842.0	60.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	8	191,184,228.1	6	125,902.1	75.0

Тус байгууллага нь Аялагыг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах, олон жилийн насжилттай аялагыг барагдуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх талаар өгсөн 2 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан гэж байгаа боловч Цагдаагийн ерөнхий газар дээр баримт нь шалгагдаж байгаа тул эцэслэн хянаж чадаагүй, баримтаар нотлогдоогүй гэж үзээд хэрэгжээгүй гэж үнэлэн, дараагийн аудитаар дахин хянаж үнэлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын хамрах хугацаанд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсгээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж, сангаас 1997-2023 оны санхүүгийн баримт материалыг эд мөрийн баримтаар хураан авч, шинжилгээнд хүргүүлсэн ба Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны 2023 оны Ви-3/12308 дугаар бүхий албан бичгээр холбогдох баримт материалыг Үндэсний аудитын газарт хүргүүлэх боломжгүйг мэдэгдсэн тул аудитын баг Боловсролын зээлийн сангаас 2023 онд эзэлээс чөлөөлсөн суралцагчдын анхан шатны баримтад аудит хийгдээгүй, дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,453,940.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд Улсын төсвийн санхүүжилтийг 114,730.5 мянган төгрөгөөр, Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх дүнг 3,349,210.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг мөрдөж ажиллаагүйтай холбоотой.

Аудитаар санхүүгийн тайлангалтай холбоотой нийт 176,659,467.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 98,284.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 147,380,658.6 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 29,180,525.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 176,659,467.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 175,117,025.2 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Ерөнхийлөгчийн нэрэмжит татгалзгар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/480 дугаар тушаалын дагуу 2022-2023 оны хичээлийн жилд гадаадад суралцахаар явсан 6 суралцагч гэрээний үүргээ биелүүлэлгүй сургуулиа хаясан байна. Эдгээр суралцагчид дотоодын бэлтгэл хөтөлбөрт 21,613.6 мянган төгрөг, сургалтын төлбөр, дотуур байрны төлбөр, амьжиргааны зардалд 11,255.82 евро, 9,966.46 ам.долларын санхүүжилт авсан байна. /Татгалзсан улс: БНХАУ, Унгар, Вьетнам, Польш, Ханш; евро 3,791.66 төгрөг, ам.доллар 3,410.69 төгрөг/

Энэ нь Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.1-д "Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангажгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй 6 суралцагчийн авсан санхүүжилтийг Боловсролын ерөнхий газрын гадаад зээлийн эргэн төлөлтийн дансанд буцаан төвлөрүүлэх.

5.2 Албан шаардлага

1. Гэрээний үүргээ биелүүлээгүй нийт 3,438,011.98 ам.долларын санхүүжилт авсан 147 зээлдэгчтэй холбоо тогтоогоогүй, зээлийн эргэн төлөлтийн график байгуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй 147 зээлдэгчтэй холбоо тогтоогоогүй, зээлийн эргэн төлөлтийн график байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

2. Өндөр хөгжилтэй оронд бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцсан нийт 462 суралцагчийн 12,635,722.97 ам.долларын зээлийн, 159 суралцагчийн 2,941,237.9 ам.долларын хүүгийн авлагын,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мөрсөн, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харилцах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хууль хүний сансгатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дэлхийн шилдэг их сургуульд суралцсан 164 харилцагчийн 19,591,404.91 ам.долларын зээлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй байна.

3. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан 13,349 суралцагчийн Оюутны хөнгөлөлттэй зээл найдваргүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д "гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил", 75.1-д "Хөөн хэлэлцэх хугацааг шаардах эрх үүсээн үеэс эхлэн тоолно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөөн хэлэлцэх хугацаа дууссан зээл найдваргүй болох эрсдэлтэй байгаа зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлсэн.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр гадаад улсад суралцаж байгаа 176 суралцагч дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөр болон гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт хоёуланд нь хамрагдаж тэтгэлэг авсан байна. Үүнд: /Польш 14, Герман 39, Франц 13, Хятад 80, Литва 1, Унгар 19, Чех 4, Энэтхэг 6 суралцагч/

Энэ нь Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын 2.1.4-т Бэлтгэл хөтөлбөрт суралцуулах тэтгэлэг (Энэ тэтгэлгийн хүрээнд гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт, эсхүл дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт суралцаж болно) гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоодын их сургуулийн бэлтгэл хөтөлбөр болон гадаадын их сургуулийн суурь хөтөлбөрт хоёуланд нь хамрагдаж тэтгэлэг авсан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлсэн.

5. Лавлагааны системийг нийт 50,000,000.00 /тавин сая/ төгрөгийн "Наргил шийдэл" ХХК-аар /2020 оны 312 тоот гэрээ/ хийлгэхээр гэрээ байгуулсан ба 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Гэрээт ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр дуусгахаар хугацаа сунгасан боловч систем, программыг эцсийн байдлаар хүлээж аваагүй, хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй, систем, программыг эцсийн байдлаар хүлээж аваагүй, ажил үйлчилгээ үзүүлэх хугацаа хэтрүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарваалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/293 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрээ байгуулан, сургалтын төлбөр шилжүүлэх эрхээ авсан 4 суралцагчийн 74,068.15 ам.долларын сургалтын төлбөрийг тайлант онд шилжүүлээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Өвсөн зөвлөмж: Сайдын тушаалаар сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчтай зээлийн гэрээ байгуулсан бол гэрээний үүргийг хангуулах ажиллах.

Илрүүлэлт 2: Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг авсан 486 суралцагчийн 20,040,494.4 мянган төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг авсан 100

Боловсролын заалгийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

оюутны 5,488,531.0 мянган төгрөг, Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцагчид олгох тэтгэлэг авсан 149 суралцагчийн 3,398,876.6 мянган төгрөгийн тэтгэлгийн гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байхад зардлаар /213205-Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал/ бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өөсөн зөвлөмж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг, Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцагчид олгох тэтгэлгийг санхүүжилт олгосон тухайд урьдчилгаа дансаар бүртгэж, гэрээний үүргийн хэрэгжилт хангагдсан үед зардлаар бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны тоон утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд Улсын төсвийн санхүүжилтийг 114,730.5 мянган төгрөгөөр, Төсөө болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх дүн 3,349,210.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн	1	3,349,210.3			1	3,349,210.3	1	3,349,210.3				
Дүн	1	3,349,210.3			1	3,349,210.3	1	3,349,210.3				

Боловсролын зээлийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/манган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
